

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР ГАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД

ГЕОДЕЗИЙН ЦЭГ, ТЭМДЭГТ

Монгол Улсын геодезийн сүлжээний Эхлэл цэг

Монгол Улсын геодезийн сүлжээний эхлэл цэгийг Архангай аймгийн Эрдэнэбулган суманд байгуулахаар шийдвэрлэж, эхлэл цэг байгуулах газрыг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 254 дүгээр тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан. Монгол Улсын геодезийн сүлжээний эхлэл цэг байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг Барилга, хот байгуулалтын яам 2017 онд баталж, 2016 онд геодезийн сүлжээний эхлэл цэгийг өндрийн I ангийн сүлжээтэй холбох өндрийн сүлжээний цэгийн судалгаа, суулгалтыг хийж гүйцэтгэсэн.

Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт байрлах өндрийн болон гравиметрийн сүлжээний геодезийн байнгын цэг тэмдэгтүүдэд хайгуул судалгаа, сэргээн босголтыг хийсэн бөгөөд Монгол Улсын геодезийн сүлжээний дагуул 3 цэгийг Архангай аймгийн Эрдэнэбулган суманд суулгасан.

Архангай аймгийн Цэцэрлэг хотод Богд Зонхов бурхны хөшөө бүхий цэцэрлэгт хүрээлэнгийн хойд хэсэгт Монголын геодезийн сүлжээний эхлэл цэгийн төв цэгийг 2019 онд байгуулсан.

Геодезийн сүлжээний эхлэл цэгийн төв цэг нь 9 метрийн урттай, 325 мм диаметртэй, 302 кг жинтэй байгууламж бөгөөд цэгийн төвд GNSS-ийн 24 цагийн тасралтгүй хэмжилтийг хийж, солбицлын утгыг тодорхойлсон /Зураг 1-д үзүүлэв/.




Зураг 1. Монгол Улсын геодезийн сүлжээний эхлэл цэгийн төв цэг

Монгол Улсын геодезийн сүлжээний байнгын цэг, тэмдэгт

Монгол Улсын хэмжээнд нийт 22977 геодезийн байнгын цэг, тэмдэгт байдаг бөгөөд Орон зай өгөгдлийн нэгдсэн мэдээллийн системээр хэрэглэгчдийг хангадаг /Зураг 2-т

үзүүлэв/. Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн
мэдээллийг <https://nsdi.gov.mn/> холбоосоор хандаж авна.



Зураг 2.Монгол Улсын геодезийн байнгын цэг, тэмдэгт